



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 24 өдөр


Дугаар 205

Улаанбаатар хот

### Барилгын тусгай зөвшөөрлийг сунгах, нэмэлт ажлын төрлөөр олгох, шинээр олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6 дахь заалт, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 21/657/ТЗ тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдүгээр хавсралтад заасан 2 /хоёр/ аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг уг хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Хоёрдугаар хавсралтад заасан 4 /дөрөв/ аж ахуйн нэгж, байгууллагад уг хавсралтад заасан барилгын нэмэлт ажлын төрлөөр тусгай зөвшөөрлийг олгосугай.
3. Гуравдугаар хавсралтад заасан 4 /дөрөв/ аж ахуйн нэгж, байгууллагад уг хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр 5 жилийн хугацаагаар тусгай зөвшөөрлийг шинээр олгосугай.
4. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгасугай.
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151030631

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн  
205 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**А. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ:**

1. "Гэрэлт цамхаг орд" ХХК, Барилга угсралт, сунгалт БА-6.3 дугаар ажлын төрлөөр;
2. "Санттри" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-3.5, 6.2 дугаар ажлын төрлөөр.

----oOo----

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн  
205 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Б. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРӨЛ ОЛГОХ:**

1. "Хангайн цац" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-2.1 дүгээр ажлын төрлөөр;
2. "Бумбод" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-4.1 дүгээр ажлын төрлөөр;
3. "Зострейд" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-2.1, 7.1 дүгээр ажлын төрлөөр;
4. "Эн эй пи групп" ХХК, Барилга угсралт, нэмэлт ЗТ-5.1 дүгээр ажлын төрлөөр  
(Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт  
баригдахаар төлөвлөгдөж буй 23 давхар "Фор сийзн гарден" ХХК-ийн  
үйлчилгээтэй орон сууцны барилгын зураг төслийн ажил).

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн  
205... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**В. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ:**

1. "Яруу буянт" ХХК, Барилга угсралт, шинэ БА-6.2 дугаар ажлын төрлөөр;
2. "Дрийм газ" ХХК, Барилга угсралт, шинэ БА-3.6 дугаар ажлын төрлөөр;
3. "Юу эл экюпмент ко" ХХК, Барилга угсралт, шинэ БА-2.1 дүгээр ажлын төрлөөр;
4. "Дельтаконстракшн" ХХК, Барилга угсралт, шинэ БА-5.1 дүгээр ажлын төрлөөр (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдахаар төлөвлөгдөж буй 24 давхар "Алтернатив клин энерги" ХХК-ийн үйлчилгээтэй орон сууцны барилгын ажил)

---oOo---